



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ**

2015 оны 03 сарын 09 өдөр

Дугаар А/29

Чингис

**Зардал гаргах тухай**

Ахмад настны нийгмийн хамгааллын тухай Монгол улсын хуулийн 6.1 дэх заалт, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам “Соён гэгээрүүлэх ажил зохиох /код 939/ журам”-ын 939.2.5г дэхь заалт, “Ахмадын байгууллага, ахмад настны талаар авах арга хэмжээ /код 946/ журам”-ын 946.4.1 дэхь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. ХҮИ жарны модон хонин жилийн сар шинийн баярын арга хэмжээг байгууллагын хэмжээнд зохион байгуулах, цагдаагийн газарт харъяалалтай ахмад настангуудын санал хүсэлтийг сонсож, ахуй амьдралтай нь танилцах, тусламж дэмжлэг үзүүлж дүнг танилцуулахыг Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа Р.Цээлхагвад үүрэг болгосугай.

2. Ахмад настан /40/ тус бүрт буцалтгүй тусламжаар 3 кг цагаан будаа, 1 кг сахар, 1 ш Өүлэн сүү, 1 ш сэтгүүл олгосугай.

3. Арга хэмжээний нэгдсэн золголт, буцалтгүй тусламжинд нийт 896000 төгрөг /Найман зуун ерэн зургаан мянга/-ийг 2015 оны батлагдсан төсвийн тэтгэмж урамшууллын зардлаас, туслах аж ахуйгаас 2 хонь зарцуулахыг ахлах нягтлан бодогч, цагдаагийн хошууч Ж.Баатарт зөвшөөрсүгэй.

4. Тушаалыг бүрэлдэхүүнд танилцуулсугай.

ДАРГА, ЦАГДААГИЙН  
ХУРАНДАА

П.ОРОСТОГОО

